



ᠰᠢᠪᠪᠡᠭᠦᠭᠦ
ᠰᠤᠮᠤᠨᠮᠡᠳᠡᠭᠡ

ШИВЭЭГОВЬ СУМЫН МЭДЭЭ



2024 оны 03-р сарын 30-наас 2024 оны 04-р сарын
12-ны хооронд хийгдсэн ажлуудаас



УСГАЛ

#Хамжихгүй бол #Амжихгүй аян


Өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрч малын зүй бус хорогдол их байгаатай холбоотойгоор өнгөрсөн 14 хоногийн хугацаанд нийт 5 удаа буюу дараах Сэг зэм устгалын ажлуудыг хийгээд байна. Үүнд:

- 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр сумын Бэхтийн булгийн ойр орчмоос эхлэн Найман шороот хүртэлх сэг зэмийг цуглуулан, Найман шороотын устгалын цэгт 1500 бог мал, 300 бод малыг хийж, ариутгал халдваргүйжүүлэлт хийн булж устгасан байна.
- 2024 оны 04-р сарын 03-ны өдөр ЗДТГ, "Илчлэг Шивээ" ОНӨААТҮГ, "МАК" ХХК-тай хамтран Сэг зэм устгалын 2 цэг дээр 2000 бог мал, 200 бод малын сэг зэмийг цуглуулан ариутгал халдваргүйжүүлэлт хийх ажлыг зохион байгуулж ажиллалаа. Мөн 7 малчин өрхөд хүнсний болон ахуйн хэрэгцээний тусламжийн хандивыг өгсөн байна.
- 2024 оны 04 дугаар сарын 05-ны өдөр сумын төвийн хогийн цэгийн ойр орчим мөн баруун талаар нутаглаж байгаа малчин өрхүүдийн сэг зэмийг цуглуулан устгах ажлыг ЗДТГ "Шивээ Овоо" ХК, "МАК" ХХК-тай хамтран 3000 мал, амьтны сэг зэмийг ариутгал халдваргүйжүүлэлт хийн булж устган овоолгыг стандартын дагуу 1,5м өндөртэй хийж гүйцэтгэлээ.



МОНГОЛЫН
ХАГААГАА

- 2024 оны 04-р сарын 9-ний өдөр сэг зэм устгалын ажлыг ЗДТГ, Цагдаагийн хэсэгтэй хамтран "Шивээ Овоо"ХК-ны ар талаас эхлэн босоо тэнхлэгийн засмал зам дагуу явж сэг зэмиЙг цуглуулан устгах ажлыг зохион байгууллаа.
- Мөн 2024 оны 04-р сарын 11-ний өдөр ЗДТГ, "Шивээ Овоо" ХК-тай хамтран 6 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг засмал зам дагуух сэг зэм цуглуулах ажлыг үргэлжлүүлэн хийж 22-р зөрлөгийн хогийн цэгт төвлөрсөн сэг зэмиЙг сумын төвийн хогийн цэгт төвлөрүүлэх ажлыг тус тус хийгээд байна.





ᠮᠤᠩᠭᠣᠯᠤᠯᠤᠰ
ᠰᠤᠮᠤᠨ
ᠰᠤᠮᠤᠨ

Хөдөө аж ахуйн талаар

Сумын хэмжээнд малын зүй бусын хорогдол нийт-14109 байна. Үүнээс:

➤ Адуу-1134, Үхэр-905, Тэмээ-1, Хонь-6920, Ямаа-5149 хорогдоод байна.

2024 оны 04 дүгээр сарын 11-12-ны өдрүүдэд Улсын Онцгой комиссоос олгож, Аймгийн Онцгой байдлын газрын Тэжээлт цэгт төвлөрсөн тэжээлийн будаанаас суманд хуваарилагдсан 1 вагон малын тэжээлийн будааг шуудайлах ажлыг зохион байгуулж, сумын малчин өрх, мал бүхий иргэдэд тараах ажил хийгдээд байна. Тусламжийн будааг сумын 98 малчин өрх, 33 мал бүхий өрх буюу нийт-131 малчдад 356 шуудайг олгоод байна. Үлдсэн малчдад тэжээлийн будааг тараах ажлыг суманд таталт хийн түгээлтийг хийхээр ажиллаж байна.





Хэвлэл мэдээллийн чиглэлээр

Өнгөрсөн 14 хоногийн байдлаар “Шивээговь сум мэдээ” цахим хуудсанд нийт 41 мэдээ мэдээлэл байршуулснаас 20 мэдээг байгууллагаас бэлтгэн байршуулж, 21 мэдээг бусад байгууллагаас шэйрлэж мэдээллэсэн байна.

Нэг цэгийн үйлчилгээг операторын горимд шилжүүлснээр e-mongolia цахим системээс 2024 оны 03-р сарын 30-наас 2024 оны 04-р сарын 12-ны байдлаар нийт 157 лавлагааг иргэдэд үзүүлсэн байна. Үүнд:

№	Үйлчилгээний нэр	Үйлчилгээний тоо
1	Иргэний оршин суугаа газрын хаягийн бүртгэлийн лавлагаа	114
2	Төрсний бүртгэлийн лавлагаа	7
3	Иргэний үнэмлэхний лавлагаа	21
4	Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тухай тодорхойлолт	6
5	Зээлийн мэдээллийн лавлагаа	1
6	Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт	4
7	Газар эзэмших эрхийн гэрчилгээний лавлагаа	3
8	Шинжилгээний хариу авах	1
Нийт - 157		





Хөдөлмөр, халамж үйлчилгээний чиглэлээр

2024 оны 03-р сарын 30-наас 2024 оны 04-р сарын 12-ны байдлаар хөдөлмөр эрхлэлт болон халамжийн үйлчилгээг нийт 50 иргэнд хүргэж ажиллаж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 25 иргэнд, нийгмийн халамжийн 9 төрлийн үйлчилгээг 25 иргэнд хүргэсэн. Үүнд:

1. Хүүхдийн мөнгөн тэтгэмж – 1 иргэн
2. Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн данс солих – 1 иргэн
3. Цалинтай ээжийн тэтгэмжид- 1 иргэн
4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр сунгалт – 1 иргэн
5. Амралт сувиллын эрхийн бичиг - 1 иргэн
6. Хиймэл шүдний хөнгөлөлт – 2 иргэн
7. Тэргэнцрийн үнийн хөнгөлөлт – 1 иргэн
8. Ахмадын өдрийн үйлчилгээнд – 16 ахмад настан бүртгэсэн.
9. Нийгмийн халамжийн үйлчилгээ болон ХЭД чиглэлийн мэдээлэл лавлагааг 17 иргэнд тус тус хүргэж ажилласан байна.

Хөдөлмөр
эрхлэлт
дэмжих
чиглэлээр



Хөдөлмөр, халамж үйлчилгээний чиглэлээр

МОНГОЛЫН
ХАМГААГАХ,
ХӨДӨЛМӨР,
ХАЛАМЖ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ТӨСӨЛ

2024 оны 4-р сарын 10-ны өдөр сумын ахмад настанд зориулсан сургалт, мэдээллийг Ахмад настны тухай хууль болон Ахмад настанд зориулсан тусгай хэрэгслийн хөнгөлөлт, амралт сувиллын эрхийн бичиг, рашаан сувиллын хөнгөлөлт болон ахмад настанд зориулсан өдрийн үйлчилгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл сургалтыг зохион байгууллаа. Тус сургалтад 16 ахмад настан хамрагдаж, “Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний БҮЛГИЙН ТӨСӨЛ”, Хөдөлмөр эрхлэлтийн сангийн “Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэг”, “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ”-ний талаар дэлгэрэнгүй мэдээлэлтэй болоод байна.






Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны чиглэлээр

ᠨᠣᠬᠤᠰᠡᠨᠢᠨ
ᠭᠢᠰᠢᠰᠢᠨᠭᠢᠰᠢᠨᠳᠤᠲᠦᠭᠦ

ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ГСАШГСЗДТГ/20240101008 дугаартай Ус хангамжийн нэмэлт эх үүсвэр, шугам сүлжээний автоматжуулалтын ажил, ГСАШГСЗДТГ/20240101004 дугаартай Цэцэрлэгийн хашааг шинэчлэн барих ажил ажлуудын тендерийг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр зарлаад байна. Тендерт сонгон шалгарагчийг 2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр шалгаруулахаар ажиллаж байна.

- Tender.mn цахим сайтад дараах тендерүүдийг зарлахаар ажиллаж байна. Үүнд:
 - Хуучин хог хаягдал булшлах, шинээр хогийн цэг байгуулах ажил
 - Нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлгийн тоог нэмэгдүүлэх, завсар үйлчилгээний ажил
 - Сургуулийн спорт заалны их засварын ажил
 - Шинэ суурьшлын бүсэд худаг гаргах ажил
 - Төрийн албан хаагчийн амьдрах орчин нөхцлийг дэмжих арга хэмжээ





МОНГОЛ
УЛСЫН
ХАМГААГАХ
МОНГОЛ

Санхүү албаны цаг үеийн мэдээ

Орон нутгийн татварын орлого 2024 оны 04 дүгээр сарын 12-ны байдлаар 16 төрлийн татварын орлого гүйцэтгэлээр 476,730,814.91 төгрөг бүрдэж, биелэлтээр 64.24 хувьтай бүрдсэн байна.

Шивээговь сумын орон нутгийн татварын орлого						
Татварын төрлийн нэр	Төрийн сангийн данс	Жилийн батлагдсан төлөвлөгөө	Өссөн дүнгээр			
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
Газрын төлбөр	100220300943	172,000,000	43,000,000	11,107,068.30	31,892,931.70	25.83
Газрын үл хөдлөх эд хөрөнгийн АТ	100220300923	-		7,205.00	(7,205.00)	#DIV/0!
Иргэний ҮХЭХАТ	100220300924			384,000.00	(384,000.00)	#DIV/0!
Галт зэвсгийн албан татвар	100220300922	1,070,000	-		-	#DIV/0!
Иргэний үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлогоос суутгасан албан татвар	100220300962	25,000,000	6,600,000	2,530,000.00	4,070,000.00	38.33
Малын тоо толгойн албан татвар	100220300917	45,000,000	-	2,393,100.00	(2,393,100.00)	#DIV/0!
Иргэний эрх борлуулсны орлого	100220300916	-		3,360.00	(3,360.00)	#DIV/0!
Хадгаламжийн хүүгийн орлогоос суутгасан албан татвар	100220300975	28,000,000	8,800,000	14,908,056.77	(6,108,056.77)	169.41
Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	100220300948	15,000,000	-		-	#DIV/0!
Улсын тэмдэгтийн хураамж	100220300941	3,500,000	1,000,000		1,000,000.00	-
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	100220300947	18,000,000	6,000,000	2,194,000.00	3,806,000.00	36.57
Хувь хүний орлогын албан татвар	100220300911	3,500,000	1,160,000	4,760,879.03	(3,600,879.03)	410.42
Цалин, хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан татвар	100220300901	1,784,520,500	684,000,000	353,107,420.07	330,892,579.93	51.62
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	100220300921	320,000,000	80,000,000	50,292,338.55	29,707,661.45	62.87
Суутгагчийн ХХ-д олгосон ОАТ / шууд бус орлого/	100220300912	6,000,000	1,500,000	35,043,387.19	(33,543,387.19)	2,336.23
Хувь хүний ОАТ-ын буцаан олголт	100220300912	(90,000,000)	(90,000,000)		(90,000,000.00)	-
Нийт дүн		2,331,590,500	742,060,000	476,730,814.91	265,329,185.09	64.24



МОНГОЛЫН
ХЭЛНИЙ
БОДЛОГЫН
САЛБАР

Боловсролын чиглэлээр

Хэлний бодлогын салбар зөвлөл, БШУГ-аас 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр зохион байгуулсан Монгол бичгийн багш нарын ур чадварын уралдаанд сумын Ерөнхий сургуулийн Монгол хэл, уран зохиолын багш Б.Дааримаа “Эвхмэл тиг” хичээлээр Тэргүүн байр, МХУЗ-ын багш Ч.Уянга “Холбох эгшгийн дүрэм” хичээлээр Гутгаар байрыг тус тус эзэлсэн байна.





МОНГОЛЫН
БУСГА АЖ АХУЙ

Боловсролын чиглэлээр

Мөн 2024 оны 04 дүгээр сарын 03-05-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулагдсан Орос хэлний Улсын олимпиадад сумын Ерөнхий боловсролын сургуулийн орос хэлний багш Б.Долгорсүрэн Говьсүмбэр аймгаа төлөөлөн оролцож Гутгаар байр эзэлсэн амжилт үзүүлсэн байна.





МОНГОЛЫН
ХАМГААГАХ, ХӨРСӨӨН
АЖААЛЗЛАХ, ХАМГААГАХ,
ХӨРСӨӨН АЖААЛЗЛАХ

АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА

